



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/351

Булган сум

Г Гэрээ байгуулах эрх олгох тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих “Аймгийн Засаг даргын тамгын газрын авто зогсоолын өргөтгөл, шинэчлэл (Булган сум)”-ийн ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан “Баян Бугат рөүд” ХХК-тай 413,708,788 (дөрвөн зуун арван гурван сая долоон зуун найман мянга долоон зуун наян найм) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2.Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн), тус хөрөнгийг холбогдох хууль, журам, гэрээний дагуу хүлээн авч данс бүртгэлд бүртгэн, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Орон нутгийн өмчийн газар (Т.Баттулга)-т тус тус үүрэг болгосугай.

3.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Баян Бугат рөүд” ХХК-ийн захирал (Ц.Алтансүх)-д даалгасугай.

4.Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг 1 дүгээр хавсралтаар, тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн ажилчид, машин механизмын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Авто замын сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг аймгийн Төсвийн ерөнхий нягтлан бодогч (О.Сайнзаяа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2026 оны
 05 дугаар сарын 12-ны/ний өдрийн
 А/351 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт




Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Магадлашгүй ажил	6,871,137	Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)
2	Захиалагчийн техник хяналтын зардал	6,871,137	Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)
3	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	3,435,569	Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)
4	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	18,000,000	Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)
5	Нормчлолын сан	618,402	Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)
6	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Б.Ариунболд (Санхүү, төрийн сангийн хэлтэс)
7	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Б.Ариунболд (Санхүү, төрийн сангийн хэлтэс) Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)
8	Гүйцэтгэлийн баталгаа	3 хувь	Б.Ариунболд (Санхүү, төрийн сангийн хэлтэс)
9	Ажил хугацаа гүйцэтгэх	2026.05.20-2026.06.30	Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)

--o00o--

Аймгийн Засаг даргын 2026 оны
 05 дугаар сарын 12-ны/ний өдрийн
 А/351 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



Тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер,
 техникийн ажилчид, машин механизмын жагсаалт

Инженер, техникийн ажилчид			Хариуцах албан тушаалтан
д/д	Албан тушаал	Ажилтны нэр	
1	2	3	4
1	Авто замын инженер	Д.Баттулга	Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)
2	Барилгын инженер	З.Оюунтуяа	
3	Геодезийн инженер	Б.Санжмятав	
4	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан	О.Оюун-Эрдэнэ	
Машин механизмын жагсаалт			Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)
д/д	Машин механизмын нэр	Улсын дугаар, хэмжээ	
1	Ачааны автомашин	1388 УЕТ	
2	Экскаватор	4245 УН	
3	Индүү	3609 УН	
4	Ковш	1472 УН	

--o00o--